



22120201



MONGOLIAN A1 – HIGHER LEVEL – PAPER 1
MONGOL A1 – NIVEAU SUPÉRIEUR – ÉPREUVE 1
MONGOL A1 – NIVEL SUPERIOR – PRUEBA 1

Thursday 10 May 2012 (morning)

Jeudi 10 mai 2012 (matin)

Jueves 10 de mayo de 2012 (mañana)

2 hours / 2 heures / 2 horas

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a commentary on one passage only.
- The maximum mark for this examination paper is *[25 marks]*.

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire sur un seul des passages.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est *[25 points]*.

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario sobre un solo fragmento.
- La puntuación máxima para esta prueba de examen es *[25 puntos]*.

Доорх хоёр зохиолын **аль нэгийг** сонгон тайбарлаж бич.

1.

Тэгээд сайн Мажигийн захисан ёсоор монголын туршуул, Эрчисийн Маань гатлагаар гатлаад тэр талаар нь өөд уруу хайж юм эс олов. Эмээлийн адаг Шар хулсаар хайвч нутаг эс олдов. Бажи Гинжилийн эхээр хайж явтал хив бүстэй, хилэн оймстой, долоон настай, гунан халтар морьтой хөвгүүн харгалдав.

5 Тэр хөвгүүнийг өрнүүн¹ хөөгөөд, асхан² гүйцэж барив. Хоёр зуун туршуул дундаа авч суулгаад, зангий нь сурав. “Хэний хөвгүүн бэ, чи? Юу хийж явав, чи? Хэл, хөвгүүн!” гэв.

“Би Байбагас ханы албат билээ. Есөн цагаан тэмээ хайж явлаа, би” гэв.

“Дөрвөн Ойрад цэрэгтэй юү, цэрэггүй юү? Нутаг нь хаа байна?” гэв.

10 Хөвгүүн хэлэв. “Таныг сурж ир гэсэн биш, барьж ир гэсэн биш үү? Үүнийг ахмадад нь хэлдэг, дээлийг захаар нь өмсдөг биш үү? Амьд хүргэгтүн, намайг! Амаараа хүрч мэдүүлье” гэв. Хөвгүүний үг энэ. Засаж дуу гаргаж ядаад, зандаж үг сурж ядаад, айлгаж ч ядаад, аргадаж ч ядаад зөвшилдөв. “Маньг сурж ир гэсэн биш, барьж ир гэсэн билээ. Үүнийг амьд хүргэе!” гээд аваад харив.

15 “Дөрвөн Ойрадын занг мэдүүл!” гэж хоёр хүн урьдаар илгээв. “Дөрвөн Ойрадын захаас долоон настай хөвгүүнийг барив. Занги нь энэ” гэв. Монголын Убаши хун тайж эхлэн олон сайн, муу, дунд гурвууланд үүнийг хэлж байтал, долоон настай хөвгүүнийг авч ирэв. Хөвгүүнийг хатуу үгтэй хөвгүүн гэхийг сонсоод найман хөлтэй, зандан ширээн дээр илд сугалаад тавив. Убаши хун тайж

20 найман тэрэмтэй, хар цоохор барсын арьсаар бүрсэн, хош³ өргөөнд долоон настай хөвгүүнийг авч ирэв. Найман хөлтэй, зандан ширээн доор сөгдүүлж суулгаад хоёр гарыг нь ард нь хүлж, баруун өвдгийг нь уулын хар барс болсон Урианхайн сайн Мажиг дарж, зүүн өвдгийг нь Баахан цэцэн дарж суув. Убаши хун тайж, хөвгүүний үгийг сурахдаа: “За, исал хөвгүүн үгээ хэл!” гэв. “Дөрвөн Ойрад цэрэгтэй юү,

25 цэрэггүй юү? Тэд юу хийж байна, хэл!” гэв.

Тэгмэгц хөвгүүн, Убаши хун тайжид мэдүүлжээ: “Ноёд, айлгалгүй сурагтун, алдалгүй мэдүүлье. Хохимнолгүй⁴ асуугтун, хоцролгүй мэдүүлье. Дөрвөн Ойрад, зарааны үс, хөрөөний шүд болж, бат дөрвөлжин болж, байнга цуг байдаг. Мэдсэнээ мэдүүлье. Үл мэдсэнийг мэдүүлж болохгүй” гэв. Убаши хун тайж,

30 хөвгүүний тэр үгэнд боогдоод, “Ойрадын наад захад хэн байна? Цэрэг, нутаг алиныг нь ч хэл!” гэв.

Хөвгүүн мэдүүлнэ: “Ойрадын наад захад тож мөнгөн дуулгатай, товруут улаан хуягтай, торгон сайхан хүрэмтэй, толботой цоохор морьтой, Мангудын хөвгүүн сайн Сэртэнги, хоёр мянган залуугаа дагуулж, хоёр мянган жадаа хатгаж,

35 хоёр мянган морио сойж, “Дайрах гөрөөс хаа байна, дайралдах дайсан хаа байна?!” гэж шүдээ хавирч, шүлсээ залгиж сууна. Ноёд түүнд дур чинь ямар байна?” “Исал, тэр чинь гайгүй. Түүний цаана хэн байдаг вэ? Хэл!” гэв. “Эрчис голын эхэнд буугаад, Иржин Харжин хоёр нутгаа цуглуулж, хар нумын цагаан элэг мэт, хамгаас ялгарч, хойд Исалбайн Сайн хиа, дөрвөн мянган залуугаа дагуулж,

40 дөрвөн мянган жадаа хатгаж, дөрвөн мянган морио сойж байна. Үхэлдэх дайсан бил үү, үгцэх залуу бил үү (амь солих дайсан байна уу, ам зөрөх хүн байна уу)? гэж, шүдээ хавирч, шүлсээ залгиж сууна. Ноёд түүнд дур чинь ямар байна?” гэв. “Исал, тэр чинь гайгүй. Түүний цаана хэн байдаг вэ? Хэл!” гэв. “Олон сүрэг хонинд довтолсон, оготор хөх чонын хэвтээ дүртэй, өнжин юм

- 45 идээгүй, өлөн бүргэдийн нүдтэй, зүүн гар Хотгойдын ноён Хар хул, зургаан мянган хүнтэй, тэр хэвээр байдаг. Ноёд түүнд дур чинь ямар байна?” “Исал тэр чинь гайгүй. Түүнээс цаана хэн байдаг вэ? Хэл!” гэв. “Нарийн голын эхэнд, нарийхан шарга морьтой, найман мянган цэрэгтэй, Урт голын бэлчирт Ойрадын сайн Тамана баатар тэр хэвээр байдаг. Ноёд түүнд дур чинь ямар вэ?” гэв. “Исал, тэр
- 50 чинь гайгүй. Түүний цаана хэн байдаг вэ? Хэл!” гэв. “Алах булагдаа дуртай, арван барсын дуутай, айхавтар таван барсын ах, хошууд Байбагас хан, түм зургаан мянган залуугаа дагуулж, арван таван тэрэмтэй, алаг байван ордондоо Дөрвөн Ойрадын төр шажин хоёрыг хүүнэж, “Дөрвөн зүгт надтай адилцах нэгэн чинээ хүнгүй буй за” гэж амаа ангайж, алгаа сарвайж сууна гэдэг. Бие минь муу
- 55 хүний хөвгүүн, би. Нас минь долоон настай, Дөрвөн Ойрадыг эргэсэнгүй, би. Ойрадын хөвгүүд дөрвөн зүгт буй. Миний занги энэ” гэв.
- Тэгээд Убаши хун тайж, тэр хөвгүүнийг авч гарч туг тай гэв.

Зохиогч нь тодорхойгүй, *Монголын Убаши хун тайжийн тууж*

¹ ернүүн: өглөө
² асхан: үдэш
³ хош: илүү
⁴ Хохимнолгүй: яаралгүй

2.

- МОРЬТОН МИНИЙ ХИШИГ ӨДӨР гэж
 Үүрэг хариуцлагаа бат ухаараад
 МОНГОЛ ТҮМНИЙ ӨСӨХ БУЯН гэж
 Өлзий цагаан сүргээ хайрлаад
 5 Тал гэдэг уудам дэвжээн дээр
 Мал сүргэн бөгцөг цацаад
 Эгшиг дуугаа аялж явах
 Эгэл малчны жаргал сайхаан.
 Элсний нь ширхэг тунгаагаагүй шижир
 10 Эгэл чулуу нь хайлгаагүй хүдэр!
 Өвгөдийн нь үг бичээгүй судар
 Үнэхээр тал минь нутаг нутгийн сор!
 Омголон салхи нь утаа исгүй цэвэр
 Оорцог цонж нь угалз хээгүй асар!
 15 Ороо зэрэглээ нь уран харшийн таталбар
 Оюу тал минь уйдашгүй амьдралын талбар.
 Тэгээд ч чи бидэн хоёр
 Тэнүүн талдаа үлдээ билээ!
 Эрдмийн танхимаа дүү нартаа орхиод
 20 Илгээлтийн эзэд болоо билээ!
 Анхны яргуй олж үзэх гэж
 Ажигч нүдээ бэлчээхийн эрэл
 Амрагийн болзоонд ОДНООР ОЧНО гэх
 Амттайхан итгэлийн аз жаргал
 25 Онгон зүрхэнд булгилан байхад
 Орчлонг найз нь тэвэрмээр байлаа.
 Онцын сайхан чамтайгаа цуг
 Од дамжиж гүймээр байлаа.
 Ороо цагаан ботго шиг үүл гэтэл
 30 Огторгуйн хаяанаас тэшүүлэн наашиллаа.
 Түмэн зээрд агт шиг угалз
 Түүний араас түрхрэн ойртлоо.
 Хадуургүй атлаа заазууртай салхи
 Харгана бутыг булгалан айсуй!
 35 Тармуургүй атлаа тэнхээтэй шамарга
 Талын хамхуулаар тэвэг өшиглөн айсуй!
 Нар халхалсан угалзны бараанаар
 Найз нь хонио гэр лүүгээ гиллээ.
 Хонь хурга дуу дуугаа авалцахын үест
 40 Хоромхон зуур, тэнгэр газар нийллээ.

Т Галсан, *Тасарсан болзоо* (1988)